



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/18/СТА-ТТЗ

Баянхонгор 2020 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: bunkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга	
1. Агуулга	1
2. Аудитын гэрчилгээ	2
3. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	9
2.8.1 Мөнгөн хөрөнгө	9
2.8.2 Авлага	10
2.8.3 Бараа материал.....	10
2.8.7 Үндсэн хөрөнгө	10
2.8.8 Өр төлбөр.....	11
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	16
2.11. Шилэн дансны мэдээлэл	16
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
4. Менежментийн захидал	16
3.1 байгууллагын үндсэн ажиллагаатай холбоотой асуудал	17
3.2. дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал.....	17
5. 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	20
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	27
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	28
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

2. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА Т
Ж.МӨНХСОЁЛ ТАНАА

2020.03.25 № 1/369
танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

005020304

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянхонгор сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

3. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ж.Мөнхсоёл-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд гүйцэтгэв.

Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дугаар сарын 06-ны өдөр 3/5 албан тоотын дугаар ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянхонгор сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Баянхонгор сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Баянхонгор сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрхлэх асуудлын хүрээний 29 байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	23	2	4	0	-
	Дүн	23	2	4	0	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан"" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 17907.7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 179.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 20086.6 сая төгрөгийн 0.5 хувь буюу 100,4 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 27 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 29 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 25 байгууллага аудитад хамрагдаж, 4 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 19, дүгнэлт өгч, “Хязгаарлалттай” 4, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас Номундалай цогцолбор сургууль, Баянхонгор сумын 11-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, 3-р цэцэрлэгүүд “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна. Үүнд:

Номундалай цогцолбор сургууль: Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, дотуур байрны хүүхдийн ирцэд дотуур байранд байхгүй, гарсан хүүхдүүдийг бүртгэж, зардлаар тайлагнасан, аудитын явцад үнэн зөв мэдээлэл өгөөгүй, тэтгэвэрт гарсан багш, ажиллагсдыг ажиллуулахдаа хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, цалингийн шатлалаар цалинжуулж, нэмэгдэл хөлс олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 21.1 сая төгрөгийн цалинг олгож, зардал хооронд гүйлгэн зарцуулсан;

11-р цэцэрлэг нь хүнсний тайлан, хоолны меню болон зарлагын баримтыг засварласнаас хоолны нормативт зардлыг 3279,8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, тээвэр шатахуун болон эм боох бараа материалын нярвын тайлан үнэн зөв гаргаагүйгээс 3251,6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлан гаргасан, жилийн эцсийн тооллогын бүртгэл нь анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангаагүй;

2-р цэцэрлэг нь тооллого хийсэн боловч, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдээгүйгээс 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын дүн нярвын бараа материалын дүнгээс нийт 24,6 сая төгрөгийн зөрүүтэй гаргасан;

3-р цэцэрлэг нь 2019 оны эцэст цалингийн зардлыг тодотгосон байхад 4906,1 мянган төгрөгийн өглөгтэй гарч төсвийг хэтрүүлсэн, тухайн тайлант хугацааны жилийн эцсийн тооллогын бүртгэл баталгаажуулах санхүүгийн тайланд тусгасан нь бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийн үнэн зөв баталгаажуулах боломжгүй, үндсэн хөрөнгө, бараа материалыг орлого авахдаа буруу ангилж бүртгэсэн, 10,0 сая төгрөгийн өртөг бүхий тоглоомыг хүлээж аваагүй байхад хөрөнгөнд орлого авсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.3 дахь “Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө .төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн” зэрэг заалтуудыг зөрчсөн мөн “Аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх” **Тохиолдсон байх**, “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” **Үнэн зөв байдал** гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Мөн Баянхонгор сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг СТАУС программ-д татуулж тулгалт хийхэд нэгтгэл хийгдэх байгууллагын жагсаалтад “Цэвэр хот” орон нутгийн өмчит ХХК, Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНТҮГ гэсэн 2 байгууллагын нэр орсноос Баянхонгор сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тулгалт зөрүүтэй гарсан ба энэ нь Баянхонгор сумын хог хаягдлын орлогыг сумын ИТХ-аар баталдаг тул сумын кодоор бүртгэгдсэн зэрэг алдаа гарсныг СТАУС программд дахин засвар хийлгэж залруулав.

**Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Д.Д	Нэр	Санхүүгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах байгууллага						Аудитын санал дүгнэлтийн төрөл				
		Аудитад хамрагдавал зохих	Үүнээс:					Бүгд тоо	Үүнээс:			
			Аудитад хамрагдаж, дүгнэлт гаргуулсан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Аудит хийгдээгүй	Зөрчилгүй		Хягаарлалттай	Сөрөг	санал дүгнэлт гаргахаас татгалзсан	
1	Баянхонгор сумын Засаг дарга	1	1				1	1				
2	Номгон ахлах сургууль	1	1				1	1				
3	Номундалай цогцолбор сургууль	1	1				1		1			
4	Эрдэм ахлах сургууль	1	1				1	1				
5	Баянхонгор сумын Эрдэнэмандал ахлах сургууль	1	1				1	1				
6	Шаргалжуут тосгоны сургууль	1					-					
7	Баянхонгор сумын Баян-ойт бага сургууль	1	1				1	1				
8	Баянхонгор сумын Соогоо- Сейко бага сургууль	1	1				1	1				
9	Баянхонгор сумын 10-р цэцэрлэг	1	1				1	1				
10	Баянхонгор сумын 11-р цэцэрлэг	1	1				1		1			
11	Баянхонгор сумын 12-р цэцэрлэг	1	1				1	1				
12	Баянхонгор сумын 14-р цэцэрлэг	1	1				1	1				
13	Баянхонгор сумын 15-р цэцэрлэг	1	1				1	1				
14	Баянхонгор сумын 1-р цэцэрлэг	1	1				1	1				
15	Баянхонгор сумын 2-р цэцэрлэг	1	1				1		1			
16	Баянхонгор сумын 3-р цэцэрлэг	1	1				1		1			
17	Баянхонгор сумын 4-р цэцэрлэг	1	1				1	1				
18	Баянхонгор сумын 5-р цэцэрлэг	1	1				1	1				
19	Баянхонгор сумын 6-р цэцэрлэг	1	1				1	1				
20	Баянхонгор сумын 7-р цэцэрлэг	1	1				1	1				
21	Баянхонгор сумын 9-р цэцэрлэг	1	1				1	1				
22	Баянхонгор сум 13-р цэцэрлэг	1	1				1	1				
23	Шаргалжуут тосгоны 8-р цэцэрлэг	1					-					
24	Баянхонгор сум 16-р цэцэрлэг	1	1				1	1				
25	Шаргалжуут тосгоны ЭМТ	1					-					
26	Баянхонгор сумын ИТХурал	1	1				1	1				
27	Баянхонгор сумын ЗДТГ	1	1				1	1				
28	Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба	1					-					
29	Баянхонгор сум Сум хөгжүүлэх сан	1				1	-					
30	Баянхонгор сумын ОНХС	1				1	-					
	Дүн	30	24	2	4	-	24	20	4	-	-	

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 8 байгууллагын санхүүгийн тайланд 113,4 сая төгрөгийн 11 алдаа зөрчлийг залруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1070.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 261.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 463.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 232.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

/ Зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаар гаргасан болно./

- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил
Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд залруулагдаагүй дараах 956,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ./зөрчлийн нэгтгэлийг хавсралтаар харуулсан болно/ Үүнд:
Сая төгрөгөөр



**Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Д.Д	Нэр	Алдаа, зөрчлийн ангилал								Аудитын илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн	
		Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	12-р цэцэрлэг			1	7.12					1	7.1
2	16-р цэцэрлэг									-	-
3	Номундалай цогцолбор сургууль	2	71.1	4	14.1	1	7.0			7	92.2
4	Сум хөгжүүлэх сан	3	34.5	1	139.5	1	111.0			5	285.1
5	Соогоо- Сейко бага сургууль	1	0.8							1	0.8
6	Баянхонгор сумын ЗДТГ	4	69.2	1	2.7	2	56.1			7	128.0
7	Баянхонгор сумын ОНХС	1	11.1	3	43.2	1	265.5			5	319.7
8	Номгон ахлах сургууль	1	-	1	1.0					2	1.0
9	Эрдэнэмандал ахлах сургууль	2	10.8	1	0.6	1	9.4			4	20.8
10	10-р цэцэрлэг	1	6.2	3	5.1					4	11.3
11	14-р цэцэрлэг			1	1.2					1	1.2
12	5-р цэцэрлэг			1	2.6	2	14.1			3	16.6
13	7-р цэцэрлэг			1	1.2					1	1.2
14	9-р цэцэрлэг			1	1.5					1	1.5
15	8-р цэцэрлэг									-	-
16	Шаргалжуут тосгоны ЭМТ									-	-
17	Баянхонгор сумын ИТХурал									-	-
18	3-р цэцэрлэг	2	6.1	3	15.5	1		1		7	21.6
19	6-р цэцэрлэг	1	2.3	3	3.4					4	5.6
20	Захирагчийн ажлын алба									-	-
21	15-р цэцэрлэг	1	1.4	1	1.3					2	2.7
22	Шаргалжуутын сургууль									-	-
23	Баян-ойт бага сургууль			2	11.2					2	11.2
24	11-р цэцэрлэг	2	12.3	2	5.3			1		5	17.5
25	1-р цэцэрлэг			1	1.9					1	1.9
26	2-р цэцэрлэг	2		2	2.5	1		1		6	2.5
27	4-р цэцэрлэг	1	0.7							1	0.7
28	Эрдэм ахлах сургууль	2	5.7	2	0.6					4	6.3
29	13-р цэцэрлэг									-	-
		26	232.1	35	261.3	10	463.1	3	-	74	956.6

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 439.8 сая, эцсийн үлдэгдэл 391,1 сая төгрөг болж, 48.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	154.9	235.6	80.7	60.24
ОНХСан	92.3	39.2	-53.1	10.02
СХСан	192.5	116.3	-76.3	29.74
Дүн	439,8	391,1	-48.7	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 391.1 сая төгрөгөөс төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 235.6 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 39.2

сая, Сум хөгжүүлэх сангийн дансанд 116.3 сая төгрөг байршиж байна. Үүнээс Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 235.6 сая төгрөгийн үлдэгдлээс 3.3 сая төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудад орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн, 232.3 сая төгрөг нь тайлант оны татварын давсан орлогоос бүрдэж байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 836,5 сая, эцсийн үлдэгдэл 926,5 сая төгрөг болж 90.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.1	2.6	-6.5
Бусад авлага	30.0	24.8	-5.2
Зээлийн авлага	797.4	899.1	101.7
Дүн	836.5	926.5	90.0

Эх сурвалж: Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 926.5 сая төгрөг байгаагаас СХС-ын зээлийн авлагын үлдэгдэл 899.1 сая, бусад авлага 27.4 сая төгрөг байна.

3.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2178.8 сая, эцсийн үлдэгдэл 1737.2 сая төгрөг болж, 441.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	297.4	384.2	86.8
Эм боох материал	2.1	23.9	21.8
Бичиг хэргийн материал	50.7	74.0	23.3
Аж ахуйн материал	226.3	281.7	55.3
Сэлбэг хэрэгсэл	7.0	11.8	4.7
Түлш, шатах тослох материал	17.1	13.7	-3.4
Барилгын засварын материал	20.7	37.9	17.2
Хүнсний материал	27.2	55.9	28.6
Бусад хангамжийн материал	376.0	811.1	235.1
Мал амьтад	8.8	9.1	0.3
Нөөцийн бараа	945.4	34.0	-911.4
Дүн	2178.8	1737.2	-441.6

Эх сурвалж: Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 30545.1 сая, эцсийн үлдэгдэл 34872.3 сая төгрөг болж, 4327.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	21,877.3	25,938.6	4,061.3
Тээврийн хэсэгсэл	240.2	241.9	1.7
Машин тоног төхөөрөмж	2,379.6	2,320.4	-59.2
Тавилга эд хогшил	1,425.6	1,655.7	230.1
Түүх соёлын дурсгалт зүйл	0.2	0.2	0.0
Номын фонд	118.6	199.9	81.3
Бусад үндсэн хөрөнгө	265.4	264.1	-1.3
Програм хангамж	87.5	31.4	-56.1
Бусад биет бус хөрөнгө	4,150.8	4,220.2	69.4
Дүн	30,545.1	34,872.3	4,327.2

Хүснэгт №4.1 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Төсвийн болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдаж авсан	Үнэ төлбөргүй хандив, тусламжаар авсан	Акталсан	Балансаас баланс-д шилжүүлж өгсөн	Эцсийн үлдэгдэл
Баян-Ойт сургууль	227.5	30.4	1,976.2	0.0	0.0	2,234.2
13-р цэцэрлэг	538.9	19.3	2.2	0.0	0.0	560.4
Цэцэрлэг /14-р/	371.0	3.1	4.6	0.0	0.0	378.7
Япон сургууль	996.1	20.9	10.0	0.0	0.0	1,027.0
4-р сургууль	2,699.4	13.2	32.2	27.4	0.0	2,717.4
9-р цэцэрлэг	583.3	3.7	4.8	0.0	0.0	591.8
11-р цэцэрлэг	864.8	0.0	59.7	0.0	57.5	867.0
16-р цэцэрлэг	0.0	43.4	38.2	0.0	0.0	81.6
12-р цэцэрлэг	547.7	5.0	6.6	3.3	0.0	556.0
15-р цэцэрлэг	52.4	17.2	763.6	0.0	0.0	833.2
Сумын ЗДТГ	1,454.0	17.9	63.8	2.4	0.0	1,533.3
Сумын ИТХурал	64.0	0.0	0.0	0.0	0.0	64.0
1-р сургууль	3,199.8	57.3	6.2	256.2	0.0	3,007.1
2-р сургууль	3,651.1	27.6	27.7	129.9	0.0	3,576.6
3-р сургууль	4,178.0	181.2	83.7	21.8	0.0	4,421.1
1-рцэцэрлэг	1,395.0	7.0	7.8	0.0	0.0	1,409.8
2-р цэцэрлэг	584.4	0.4	2.2	8.3	0.0	578.6
3-р цэцэрлэг	776.2	12.9	2.2	0.0	0.0	791.3
4-р цэцэрлэг	780.1	10.0	3.8	5.3	0.0	788.7
10-р цэцэрлэг	2,169.2	4.7	4.1	3.2	0.0	2,174.9
7-р цэцэрлэг	694.3	4.5	2.2	0.0	0.0	701.0
5-р цэцэрлэг	881.7	1.5	3.7	3.0	0.0	883.9
Хотын захирагчийн алба	286.1	0.0	51.0	0.0	0.0	337.1
Шаргалжуутын сургууль	594.4	31.2	10.5	0.0	0.0	636.1
Сумын эмнэлэг	1,240.4	31.2	3.8	0.0	0.0	1,275.4
8-р цэцэрлэг	1,248.4	0.6	0.0	0.0	0.0	1,249.0
6-р цэцэрлэг	466.6	2.0	1,132.0	3.2	0.0	1,597.4
Дүн	30,545.1	546.0	4,302.8	464.1	57.5	34,872.3

Эх сурвалж: Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 545.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4302,8 сая төгрөгийн хөрөнгийг хандив, тусламж, үнэ төлбөргүй авсан, 464.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 57,5 сая төгрөгийн хөрөнгийн бусад шилжүүлгээр зарцуулсан байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6.4 сая, эцсийн үлдэгдэл 13.2 сая төгрөг болж 3.75 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	1.5	7.2	5.7	51.55
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	1.9	1.9	14.39
Бусад өглөг	4.9	4.1	-0.8	31.06
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-

Нийт дүн	6.4	13.2	6.8	100.0
-----------------	------------	-------------	------------	--------------

Эх сурвалж: Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст ажиллагсадтай холбоотой өглөг 7.2 сая, бараа үйлчилгээний зардлын өглөг 1.9 сая, бусад өглөг 4.1 сая төгрөг байна. Өглөгийн дэлгэрэнгүй үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав.

№	Төсвийн захирагч	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллага хоорондын
1	Баян-Ойт сургууль	0.0	3.8	0.0	3.8
2	13-р цэцэрлэг	0.0	0.3	0.3	0.0
3	ОНХсан	1.4	0.8	0.0	0.8
4	Сум хөгжүүлэх сан	0.0	0.1	0.0	0.1
5	4-р сургууль	0.2	0.7	0.7	0.0
6	9-р цэцэрлэг	0.2	0.4	0.4	0.0
7	15-р цэцэрлэг	0.0	1.4	1.4	0.0
8	Сумын ЗДТГ	2.3	0.0	0.0	0.0
9	Сумын ИТХурал	0.0	0.0	0.0	0.0
10	1-р сургууль	1.7	0.4	0.0	0.4
11	1-рцэцэрлэг	0.0	0.0	0.0	0.0
12	2-р цэцэрлэг	0.0	0.4	0.0	0.4
13	3-р цэцэрлэг	0.0	4.9	4.9	0.0
14	5-р цэцэрлэг	0.1	0.0	0.0	0.0
15	Хотын захирагчийн алба	0.0	0.0	0.0	0.0
16	Сумын эмнэлэг	0.5	0.0	0.0	0.0
17	8-р цэцэрлэг	0.1	0.0	0.0	0.0
Дүн		6.4	13.2	7.6	5.5

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 30607.6 сая, эцсийн үлдэгдэл 33764.5 сая төгрөг болж 3.156.9 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	14,217.1	14,217.1	0.0	42.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,728.1	12,708.5	(19.6)	37.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөл	-	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	3,662.3	6,838.8	3,176.5	20.3
Дахин үнэлгээний нөөц	-	-	-	-
Дүн	30,607.6	33,764.5	3,156.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс өөрчлөлт нь тайлант оны хуримтлагдсан үр дүн 3156.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.9 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 07-ны 11/7 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 1333,7 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1582.6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 119 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	1,333.7	1,582.6	248.9	119%
1.1.ИОТХ	201.00	248.66	47.7	124%
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	470.00	559.91	89.9	119%
1.3. ҮХЭХ борлуулсан	100.00	135.94	35.9	136%
1.4. Бууны татвар	4.80	5.40	0.6	113%
1.5.Улсын тэмдэгтийн хураамж	18.50	13.05	-5.4	71%
1.6.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	430.30	424.38	-5.9	99%
1.7.ТТАМАТөлбөр	0.00	0.10	0.1	
1.8. Газрын дуудлага худалдаа	0.00	54.08	54.1	
1.9 Нохойны татвар	1.00	1.00	0.0	100%
1.10 Газрын дуудлага худалдаа	0.00	0.54	0.5	
2.Татварын бус орлого	0.00	0.00	0.0	
2.1 Хүү торгуулийн орлого	108.10	139.52	31.4	129%
ТБӨО	10.10	8.62	-1.5	85%
Нийт дүн	1,343.8	3,034.27	1,690.5	135.4

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 19725,7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 19316,7 сая төгрөгийг урсгал зардалд, 408.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 14814.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 4069.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 14.2 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 316.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 226.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос, 284.9 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авсан харин эрүүл мэндийн даатгалын сангаас 4,3 сая төгрөгийн санхүүжилт дутуу, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 14817,4 сая төгрөг буюу 3,4 сая төгрөг илүү авсан байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт илүү авсан 3,4 сая төгрөг нь Шаргалжуутын ЭМТ-д олгогдсон ба нийт дүнгээрээ 27.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 214.8 сая төгрөг бүрдүүлж, орлого төлөвлөснөөс 11.6 сая төгрөгөөр тасарсан нь СХС-ийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 19522.6 сая төгрөг буюу 98.97 хувьтай байгаа нь нийт зардал 0.6-аас 203,2 сая төгрөгөөр зарцуулагдаагүйтэй холбоотой ба энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 123.6 сая буюу СХС-гийн зээлийн олголт,

цалингийн зардал 10.5 сая төгрөг гэх мэт тодорхой хэмжээгээр зардлын гүйцэтгэл буурсан байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар

/сая.төг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Баян-Ойт сургууль	712.1	707.7	(4.4)	99.38%
13-р цэцэрлэг	298.8	298.4	(0.4)	99.88%
ОНХсан	409.0	371.7	(37.3)	90.88%
Сум хөгжүүлэх сан	408.4	280.5	(127.9)	68.68%
Цэцэрлэг /14-р/	214.1	214.1	(0.0)	100.00%
Япон сургууль	743.6	739.9	(3.7)	99.51%
4-р сургууль	1,603.7	1,599.9	(3.8)	99.76%
9-р цэцэрлэг	272.2	272.2	(0.0)	100.00%
11-р цэцэрлэг	404.2	404.2	-	100.00%
16-р цэцэрлэг	231.6	231.6	(0.0)	100.00%
12-р цэцэрлэг	363.6	363.1	(0.5)	99.88%
15-р цэцэрлэг	296.7	296.3	(0.4)	99.87%
Сумын ЗДТГ	1,383.3	1,382.4	(1.0)	99.93%
Сумын ИТХурал	143.4	143.4	(0.0)	99.98%
1-р сургууль	3,280.7	3,278.6	(2.0)	99.94%
2-р сургууль	2,337.2	2,334.5	(2.7)	99.89%
3-р сургууль	1,982.3	1,982.3	(0.0)	100.00%
1-рцэцэрлэг	609.7	608.4	(1.4)	99.77%
2-р цэцэрлэг	322.8	322.3	(0.5)	99.85%
3-р цэцэрлэг	417.3	417.2	(0.1)	99.98%
4-р цэцэрлэг	321.7	321.5	(0.1)	99.96%
10-р цэцэрлэг	514.8	507.2	(7.6)	98.52%
7-р цэцэрлэг	390.6	390.5	(0.1)	99.98%
5-р цэцэрлэг	525.0	525.0	(0.0)	100.00%
Хотын захирагчийн алба	54.1	53.8	(0.3)	99.52%
Шаргалжуутын сургууль	471.7	468.1	(3.6)	99.25%
Сумын эмнэлэг	316.1	310.7	(5.4)	98.28%
8-р цэцэрлэг	214.9	214.8	(0.1)	99.97%
6-р цэцэрлэг	482.2	482.2	(0.0)	100.00%
Нийт дүн	19,725.7	19,522.6	(203.2)	98.97%

Хүснэгт 10.1 Төсвийн гүйцэтгэл. Бүлгийн дүнгээр /сая төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,725.7	19,522.6	(203.18)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,501.5	11,490.9	(10.53)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,483.5	1,479.8	(3.70)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,437.5	2,430.0	(7.46)
2104	Хангамж, бараа материалын зардал	288.2	283.8	(4.41)
2105	Нормативт зардал	1,070.5	1,065.9	(4.61)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	710.6	708.0	(2.63)
2107	Томилолт, зочны зардал	34.7	34.0	(0.68)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,034.8	911.2	(123.61)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	310.2	306.6	(3.63)
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	445.2	440.5	(4.63)
22	Хөрөнгийн зардал	409.0	371.7	(37.28)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,725.7	19,393.2	(332.56)
1310	Улсын төсвөөс	14,814.0	14,790.1	(23.87)
132001	Орон нутгийн төсвөөс	4,070.0	4,061.7	(8.32)
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	316.7	316.7	(0.00)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14.2	9.9	(4.32)
1200041	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	226.0	214.8	-11.2
1200043	Өмнөх оны үлдэгдлээс	284.8		

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 173,7 сая, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 167,2 сая, нөөц хөрөнгөөс 1,3 сая нийт 342,3 төгрөгийн нэмэлт бүрдүүлж, цалингийн зардалд 3,6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 227,5 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 15,9 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны зардалд 73,4 сая төгрөгийг зарцуулан 7,2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа /сая.төг/

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт
Япон сургууль	19.4	19.4
4-р сургууль	17.7	17.7
12-р цэцэрлэг	4.0	4.0
Сумын ЗДТГ	69.8	69.8
Сумын ИТХурал	0.5	0.5
1-р сургууль	81.3	81.3
2-р сургууль	38.1	38.1
3-р сургууль	80.9	80.9
1-р цэцэрлэг	9.5	9.5
2-р цэцэрлэг	3.3	3.3
7-р цэцэрлэг	2.8	2.8
5-р цэцэрлэг	7.0	7.0
6-р цэцэрлэг	7.8	7.8
Нийт дүн	342.3	342.3

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ
Дараагийн аудитаар анхаар ч үзэх асуудал байхгүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

д.д	Хугацаа	төрөл	удаа	хугацаан даа оруулсан	хоцорсон	хугацаа болоогүй
1	Бүтэн жилээр	12	12	9	2	1
2	хагас жилээр	3	3	3	0	0
3	улирал бүр	2	8	8	0	0
4	сар бүр	5	60	50	10	0
5	тухай бүр	6	72	51	21	0
6	ДҮН	28	155	121	33	1

Баянхонгор сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 121 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээлэлд дахин завсар хийснээс хугацаа хоцроосон төлөвтэй болж 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

4. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

